



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 326

Улаанбаатар хот

"Индралхур ХЗХ"-нд тусгай зөвшөөрөл олгох тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 15 дугаар зүйлийн 15.3, Санхүүгийн зохицуулах хорооны 60 дугаар тогтоолоор батлагдсан "Хадгаламж зээлийн хоршооны зохицуулалтын журам"-ын 4.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний журам"-ын 1.2, 1.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Индралхур ХЗХ"-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг "Индралхур ХЗХ" /Ш.Тулга/-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-д, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүргэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000907